



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 дугаар сарын 08

Дугаар А/52

Улаанбаатар хот

Дүүргийн Нийгмийн даатгалын газрын
зохион байгуулалтын бүтэц, орон тоог
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.1 дэх заалт, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 469 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 2.1, 2.2 дахь хэсэг, 2016 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 4 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны "Хууль хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 138 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц батлах тухай" А/19, А/74 дүгээр тушаал, 2024 оны "Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагын орон тооны хязгаар батлах тухай" А/45 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын байгууллагын ажлын ачааллыг нягтруулах, үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор тухайн дүүргийн хүн ам, ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо болон үйлчилгээний хамрах хүрээг харгалзан "Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Багануур, Багахангай, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц"-ийг хоёрдугаар хавсралтаар, "Дүүргийн Нийгмийн даатгалын газрын орон тооны хязгаар"-ыг гуравдугаар хавсралтаар, "Дүүргийн Нийгмийн даатгалын газар, нэгжүүдийн орон тоо, албан тушаалын жагсаалт"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан нэгжийн дарга, байцаагч, ажилтнуудыг томилон ажиллуулах, нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлахыг дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

1524010303

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Тамгын газар (Б.Батсүх)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Бүтэц, орон тоо батлах тухай" 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын орон нутгийн салбар нэгжийн бүтэц"-ийн болон дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Нийслэлийн нийгмийн даатгалын газар (хэлтэс)-ийн зохион байгуулалтын бүтэц"-ийн дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст холбогдох хэсэг, мөн тушаалын зургаадугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын орон нутгийн салбар нэгжийн орон тооны дээд хязгаар"-ын дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй холбогдох хэсгүүдийг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Орон тоо, албан тушаалын жагсаалт шинэчлэн батлах тухай" 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/131 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2024 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн 146
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР,
НЭГЖҮҮДИЙН ОРОН ТОО, АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал	Орон тоо
Нэг.Удирдлага			1
1	Газрын дарга	T3	1
Хоёр.Захиргаа, хяналтын хэлтэс			19
2	Хэлтсийн дарга	T3	1
3	Хяналт шалгалтын байцаагч	T3	6
4	Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч	T3	1
5	Хүний нөөцийн мэргэжилтэн	T3	1
6	Хуулийн мэргэжилтэн	T3	1
7	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3	1
8	Мэдээллийн технологийн ажилтан	TY	1
9	Бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтан	TYM	1
10	Архивын ажилтан	TYM	2
11	Үйлчлэгч	TY	2
12	Төсвийн байгууллагын үйлчилгээний ажилтан	TY	2
Гурав.Санхүү бүртгэлийн хэлтэс			7
13	Хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч	T3	1
14	Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн	T3	2
15	Сангийн нягтлан бодогч	TYM	2
16	Үйл ажиллагааны нягтлан бодогч	TYM	1
17	Хөрөнгө хариуцсан ажилтан	TY	1
Дөрөв.Хамралт, орлогын хэлтэс			14
18	Хэлтсийн дарга	T3	1
19	Хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч	T3	9
20	Өр, авлага хариуцсан мэргэжилтэн	T3	2
21	Сайн дурын даатгалын байцаагч	T3	2
Тав.Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс			19
22	Хэлтсийн дарга	T3	1
23	Тэтгэврийн хяналтын байцаагч	T3	2
24	Тэтгэмжийн хяналтын байцаагч	T3	1
25	Тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч	T3	2
26	Тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч	T3	2
27	Тэтгэврийн хувийн хэргийн бүртгэл хариуцсан байцаагч	T3	1
28	Магадлагч эмч мэргэжилтэн	T3	1
5.1.Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг			9
29	Тасгийн дарга	T3	1
30	Нэг цэгийн үйлчилгээний байцаагч	T3	7
31	Цахим үйлчилгээ хариуцсан байцаагч	T3	1
Нийт орон тоо			60